



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 1/497

Номгон

Г
Иргэн Д.Ганбаатарын эзэмшил газрыг
хуваах тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Газар эзэмшигч иргэн Д.Ганбаатарын Рашаант 10 дугаар баг, Таван-
Эрдэнийн гудамж-1, 115 тоот хаягт байрлах 5-8 давхар нийтийн орон сууцны
зориулалттай 2 орон сууцны 3563 м2 эзэмшил газрыг 1685 м2, 1878 м2 болгон 2
хувааж нэгж талбарыг кадастрын зурагт тусгагдсаны дагуу хавсралтаар
баталсугай.

2.Эзэмшил газар хуваагдсантай холбогдуулан эзэмшил газрыг улсын
бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, эзэмшил
газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс
(Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрын 10 хувийг цэцэрлэгжүүлж зориулалтын дагуу зүй
зохистой ашиглахыг газар эзэмшигч иргэн Д.Ганбаатарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

: 601210143

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын
06-ны өдрийн А/497 дугаар захирамжийн хавсралт

ХУВААГДАЖ БҮЙ 2 НЭГЖ ТАЛБАРЫН ЖАГСААЛТ

Эзэмшигчийн газрын мэдээлэл								
№	Нэр	регистрийн дугаар	нэгж талбарын дугаар	Нийт талбарын хэмжээ м2	Хаяг	Зориулалт	Хуваагдаж буй талбайн хэмжээ /м2/	Хуваагдсан нэгж талбарын Зориулалт
1	Д.Ганбаатар	ВП72022819	6409009718	3563 м2	Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Таван-эрдэнийн гудамж- 1, 115 тоот	5-8 давхар нийтийн орон сууц	1685 м2	5-8 давхар нийтийн орон сууц
					Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Таван-эрдэнийн гудамж- 1, 117 тоот	5-8 давхар нийтийн орон сууц	1878 м2	5-8 давхар нийтийн орон сууц

_____ оОо _____